

Ховд Политехник коллежийн сургалтын вйл ажиллагааны

тухай сургалтын албаны дарга П.Өлзийбуянтай ярилцлаа.



-Сургуулийнхаа сургалтын вйл ажиллагааныхаа тухай ерөнхийд нь танилцуулах уу?

-2013-2014 оны хичээлийн жилд манай сургууль 1234 оюутантай, 71 багш, 51 ажиллагсад, 8 удирдах ажилтантайгайр сургалтын вйл ажиллагаа явуулж байна. Ер нь бол боловсон хvчний бvрэлдэхvнний хувьд 116 багш ажиллагсадтай, vнээс 71 нь багш, 10 нь удирдах ажилтан, 37 нь вйлчилгээний ажилтан байгаа. Багшлах боловсон хvчнийг эрдмийн зэрэг цолоор нь авч vзвэл: Доктор 1, магистр 22, бакалавр 36, дипломын боловсролтой 12 багш бий. Нийт багш нарын 30 хувь нь эрдмийн зэрэг цолтой. Мэргэжлийн зэргийн хувьд тэргvвлэх 6, заах аргач 38 багш байгаа.

-Энэ хичээлийн жилд 1200 гаруй оюутан элссэн гэж байна. Өмнөх жилтэй харьцуулахад өссөн vв, буурсан уу?

-Омнох 2012-2013 оны хичээлийн жилд манайх Оюунтолгойн тослийн сургалтанд хамрагдасдыг оруулаад 1718 оюутантайгаар сургалтын вйл ажиллагаа явуулсан.

Оюу толгойн тослийн сургалтанд хэдэн суралцагч хамрагдсан бэ? 300 хvн хамрагдсан. Энэ жилийн хувьд манай элсэлтийн тоо энэ 300 хvнийг оролцуулахгvйгээр 200-гаад оюутнаар буурсан харагдаж байгаа байх

-Элсэгчдийн тоо буурах болсон нь юунаас шалтгаалсан гэж vзэж байна вэ?

- Манайд мэргэжлийн боловсрол эзэмшиж буй 24-ээс доош насны оюутнууд тэтгэлэг авдаг. 24-ээс дээш насныхан болохоор тэтгэлэгт хамрагддаггvй юм. Vнээс шалтгаалаад хэдийгээр хэрэгцээ шаардлага байгаа ч гэсэн 24-ээс дээш насныхан элсэх нь бага байдаг. Бид тvншлэгч байгууллагаас тавьж буй санал мон тодорхой судалгааны байдлыг харгалзан, тэтгэлэггvйгээр 1 жил суралцаад ажлын талбарт гарах зориулалтаар элсvвлэн сургах элсэгчид буюу мэргэжлийн сургалтын торлийн элсэгчдийн тоог нэмж, тэтгэлэгтэй элсэгчдийн тоог тодорхой хувиар бууруулсан. Яагаад гэвэл нийгэмд ийм хэрэгцээ их байна. Сургууль тогсчихсон ажилгvй залуус, иргэд олон байна шvв дээ. Тэднийг мэргэжил эзэмшvвлээд гаргавал ажлын байр жилээс жилд нэмэгдэх хандлагатай болоод байгаа. Гэтэл дахиад л энэ торолд хvмvvc цоохон элслээ. Энэ нь юунаас шалтгаалж байна гэвэл хvмvvc тэтгэлэг степендтэй л гэвэл тэр зvг рvв хошуурдаг, тийм биш гэвэл дурамжхан ханддаг явдал байсаар байна. Оюутнууд манайд элсэж суралцахын тулд тэтгэлэгтэй юу л гэж асуудаг юм. Энэ онд мэргэжлийн сургалтын торолд элсэгчдийн тоо толовлосноос нэлээд доогуур байгаа нь бас л vвнтэй холбоотой.

Учир нь манайх энэ торлийн элсэгчдэд тэтгэлэг олгохгвйгээр внэгвй суралцуулдаг бол Оюутолгой тослийн хүрээнд явагдаж байгаа сургалт нэг суралцагчид сард 190000 тогrogийн тэтгэлэг олгодог. Тиймээс сонирхсон хvmvvc нь бvгд тийшээ хошуурч байна. Тvvнд багталгвй vлдсэн нь л манайд элсэж байна гэсэн vг.

-Техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалт гээд ангилаад байгаагийнхаа ялгаа заагийг тайлбарлахгвй юу?

-Техникийн боловсрол гэдэг маань еронхий боловсролын сургууль тогсогчид 3 жил суралцаад дипломын дээд боловсролтой болно гэсэн vг. Мэргэжлийн боловсрол нь 2.5 жил тэтгэлэгтэйгээр суралцаад бvрэн дунд боловсролын внэмлэхтэй бас мэргэжлийн внэмлэхтэй тогсоно. Мэргэжлийн сургалт гэдэг нь насанд хүрэгчдийг элсvүлж 1 жил сургаад зовхон мэргэжлийн внэмлэхтэй мэргэжлийн зэрэгтэй тогсгодог сургалт юм.

-Танай коллеж энэ хичээлийн жилд хэдэн төрөл мэргэжлээр сургалт явуулж байна?

-Энэ хичээлийн жилд нийтдээ 23 төрөл мэргэжлээр сургалтын вйл ажиллагаа явуулж байгаа.

-Сургалтын вйл ажиллагаатай холбоотой нэг зvйлийг сонирхоход Баруун бvсийн Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл гэж хэрэгжиж байгаа гэсэн энэ төслийн хүрээнд ямар ажлууд хийгдэж байгаа юм бэ?

- Энэ тосол нь баруун бvсийн Ховд, Баян-Олгий, Увс, Говь-Алтай, Завхан, Баянхонгор зэрэг 6 аймагт 2012 оны 11 сараас эхлэн 2 жилийн хугацаатай хэрэгжиж байгаа. Тослийн хүрээнд Ходолморийн зах зээлийн судалгааг гаргах, жимс, жимсгэнэ, хvнсний ногоог боловсруулах, хадгалах, савлах вйлдвэрлэлийн мэргэжлийн ЧСС- хотолбор боловсруулах, тухайн торлийн вйлдвэрийн тоног тохооромжийг нийлvүлж суурилуулах, мэргэжлийн дадлагын сургалтын байрыг засварлах мон ходолморийн яармаг, туршилтын сургалт зохион байгуулах, удирдлагыг чадавхижуулах сургалтууд явуулах, нарийн мэргэжлийн багш бэлтгэх ажлууд хийгдэх юм.

-Төслийн явц ямар байна?

- Жимс, жимсгэнэ, хvнсний ногоог боловсруулах,чиглэлийн сургалтын хотолборийг боловсруулж дууссан. Энэ торлийн тоног тохооромжоор хангах зориулалтаар 100 сая тогрогийн хоронго оруулалт хийгдэх юм. Ажлын байрыг нь засварлах ажил хийгдэж байгаа. Удирдлагыг чадавхижуулах сургалтууд графикийн дагуу явж байна. Бусад ажлууд цаашид толовлосний дагуу хэрэгжинэ.

-Ярилцсанд баярлалаа. Та бvхний ажилд амжилт хvсье.

Ярилцсан
Г.Үнэнтоль